

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

ХИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЛБАНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Г.Гантулга, Б.Балсандорж. ДХИС-ийн Удирдлагын академийн
8012 дугаар дамжааны магистрант

Товч агуулга:

Хилийн төлөөлөгчийн албаны удирдлага, зохион байгуулалтын төвхэн уламжлал, удирдлага, зохион байгуулалтын нөхцөлийн байдал, түүнд тулгамдаж буй зарим асуудлыг сайжруулах арга замын талаар санаа дэвшүүлэхэд оршино.

Abstract:

To solve problems in head administration of Deputy of border patrol, traditional customs of its system and its management.

Төлхөөрөгс:

Хилийн төлөөлөгчийн алба, удирдлага, зохион байгуулалт, уламжлал шинэчлэл, тулгамдсан асуудал

Keywords:

The agent of Deputy of border patrol, the administration, system, tradition and revival

Оршил. Монгол улсын хил дээр улсын болон ард түмнийхээ ашиг сонирхлыг хамгаалах хилийн дипломат ажиллагааны үндсэн хэлбэр нь хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа байдаг. Хилийн дипломат харилцаа нь улсын хилийн дэглэмийг хилийн бус, зурвас, хязгаар нутагт сахиулах, хил залгаа улстайгаа сайн хөршийн харилцаа тогтоох, олон улсын гэрээгээр хөлээсэн өөргөө биелүүлж, хэрэгжүүлэх явдлаар илэрдэг.

Хилийн төлөөлөгчийн ажиллагаа нь хилийн зөрчил, будиланыг зохицуулах, хилийг зөрчилгүй байлгахад чиглэгдсэн өвөрмөц арга хэлбэр бөгөөд тусгайлан сургаж бэлтгэсэн офицерууд өөрөг үйцэтгэдэг онцгой бэрэн эрхтэй ажиллагаа юм.

Хил дамнасан гэмт хэргийн бэлгэлэлд нь тухайн орны хууль, эрх зүйн хөрөөнээс гадуур хэд хэдэн улс орон дамжин хууль зөрчиж, гэмт үйл ажиллагаа явуулан, үйлдсэн гэмт хэргээсээ олсон

ашиг, орлогоо мөн хил дамнуулан зувчуулж гаргадаг онцлогтой. Энэ нь аливаа улс оронд аюулгүй байдлаа хангах мэднээс улсынхаа хил хамгаалалт, хилийн хяналтын болон хууль сахиулах төрийн байгууллагууд нь мийл ажиллагаагаа улам бүр боловсронгуй болгох, хил залгаа улсууд болон бусад улс орны ижил төстэй байгууллагуудтай хамтран тэмцэх, нягт хамтран ажиллаж шаардлагыг бий болгож байна.

Нэг. Хилийн төлөөлөгчийн албаны төөхөн уламжлал, удирдлага зохион байгуулалт. Дэлхийн улс орнууд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа улс төр, нийгэм, эдийн засаг, хууль, эрх зүй, цэрэг зэвсгийн бодлогоороо тодорхойлж, улс орныхоо хөгжил дэвшлийг хангах, хадгалах, олон улсын болон бус нутгийн төвшинд эзлэх байр сууриа бататгах, хил хязгаар, нутаг дэвсгэр, хамнамынхаа аюулгүй байдлыг хангах олон талт бодлого мийл ажиллагааг тасралтгүй явуулсаар ирсэн төөхтэй.

Хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тогтоосон дэглэмийг сахиулах, улсын хил дээр өссөн хилийн аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор хилийн цэргийн байнгын бүрэлдэхмнээс тусгайлан томилогдсон офицеруудын хичээр хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай хамтран явуулж буй дипломат арга хэмжээг хилийн төлөөлөгчийн ажиллагаа гэх бөгөөд улс орны эрх ашгийг улсын хил дээр хамгаалах арга хэлбэрийн нэг юм.

Хилийн төлөөлөгчийн албаны өссэл, хөгжлийг Монгол, Оросын хил ба хойд хил, Монгол Хятадын хил ба мнөд хилд тус тус авч мэдэг.

Улсын хилийг хилийн төлөөлөгчийн ажиллагаагаар хамгаалж ирсэн байдал, төөний өссэл, хөгжил нь улсын өссч бүрэлдэн бий болсон байдал болон улсын хил, төөний хамгаалалтын төөхтэй салшгүй холбоотой.

Монгол Улсын хойд хил нь Оросын хаант улс, Манж гөрний хооронд анхнаасаа улсын хилийн чанартай гэрээ, эрх зүйн мндсэн дээр 1727 оны буурын голын хилийн гэрээ, 1864 оны Тарвагатай хотын хилийн гэрээнмдээр өссгэгдэн тогтсон билээ. Хойд хилийг

энэ тусгаар хамгаалж ирсэн бөгөөд хилийн төлөөлөгчийн ажиллагаа болсон хөгжиж нэмэгдэх үрчээ.¹

Монгол улс мөнд хил нь тусгаар улсуудын хооронд хил тогтоодгоос эрс ялгаатай төлөлтэй ба Ар Монгол нь Манжид эзлэгдсний дараагаас эхлэн /Ар Монгол, Зүүр Монгол, Шинжаан аймаг/ нутаг бэлчээрийн хуваарь энэ талаар удаа дараалан гарч байсан зарга маргааныг Манжийн захирагч нарын оролцойтойгоор таслан шийдвэрлэж, бодовч, баримжаагаар тогтоосон нутаг бэлчээрийн хуваарь захыг Халхын зүүг дээдэс, ард олноос мөрдөн дагаж, эзэмшин хамгаалж ирсний үр дүнд болсч бэрэлдэн бий болсон байдаг.

Орон нутгийн шинж чанартайгаас болсон бэрэлдсэн мөнд хил нь 1911 онд Манжийн дарлалыг устган Олноо эргэгдсэн Монгол Улс байгуулснаар Манжийн биш Монгол Улсын хил болсон бөгөөд улмаар 1921 онд ардын хувьсгал ялснаар 1924 онд Ардын Эрхт Бүгд Найрамдах улс болсноо анхдугаар бодсон хуулиар баталгаажуулж, хил хязгаараа сэргийлэн хамгаалах, элбэн тохинуулах цэрэг илгээж, хязгаарын сайдуудыг томилсон байдаг. Энэ тусгаар Монгол, Хятадын хилд улсын хилийг хилийн төлөөлөгчийн ажиллагаагаар хамгаалах эхлэл тавигдан хязгаарын сайдууд нь хилийн төлөөлөгчийн үүргийг биелүүлж эхэлсэн байдаг.²

Хилийн төлөөлөгчийн албаны үйл ажиллагаа нь Монгол, Оросын улсын хилийг тогтоон тэмдэглэсэн төлөөс эхлэлтэй гэж болдэг.

Удирдлага, зохион байгуулалт

Хилийн төлөөлөгчийн албаны удирдлага зохион байгуулалтын үндсний байдал нь Монгол Улсын хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон Улсын гэрээг хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн зөрчлөхс урьдчилан сэргийлэх хилийн дэглэм сахиулах, гарсан хилийн аливаа асуудлыг Монгол улсын эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх хариуцлагатай үүрэг гүйцэтгэх зорилгоор явагддаг дипломат ажиллагаа бөгөөд энэхүү онцгой

¹ Ганболд.Ц. “Монгол Улсын хилийн төлөөлөгч, төлний үйл ажиллагааг боловсронгуй болгох нь”

Диссертаци. УБ., 2004 он. 11 дэх тал

² Мөн тэнд

бүрэн эрх бүхий албанд өөрөг гүйцэтгэх албан тушаалтанг хил хамгаалах байгууллагаас тусгайлан томилдог.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Улсын хил хамгаалалт нь нндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн”, мөн хуулийн 4 дүгээр бүлгийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Улсын хилийн халдашгүй дархан байдлын хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон Улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөх с урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, ХИЛИЙН ТӨЛөөлөгчийн арга хэмжээг хослуулан зохион байгуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ” хэмээн хуульчилсан.

Хил хамгаалах үйл ажиллагааны аргууд нь цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, ХИЛИЙН ТӨЛөөлөгчийн арга хэмжээнээс бүрдэж байна. Иймд манай хоёр хөршийн хувьд дэлхий дахинд өөрсдийн эрх ашиг, бодлогоо тодорхойлон, том гүрэнүүдийн тоглоомонд байр сууриа эзлэн оролцож байгаа нөхцөлд хөрш улсуудтайгаа бид хилийн асуудлаар байгуулсан гэрээ хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, бодлогыг тодорхойлох, хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааг менежмент удирдахуйн ухаантай судлах нь зайлшгүй хэрэгтэй байна.

Монгол Улсын хилийн төлөөлөгч гэж: Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийг хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн дэглэм сахиулах, хилийн зөрчлөх с урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх чиг өөрөг бүхий Монгол Улсын хилийн төлөөлөгч төрний орлогчийг улсын хил хамгаалах байгууллагын дарга томилно.¹

Нөхцөдийн байдлаар дэлхийн газар нутаг ндсэндээ 200 гаруй улс гүрнүүдэд хуваагдаж, зарим улс орнууд далай тэнгис, Арктик болон Антрактидын бүс нутаг, сансар огторгуйг хөгжлийн

¹ Монгол Улсын хилийн тухай хууль.2 дугаар бүлэг. 23 дугаар зүйл. Төрийн мэдээлэл 2017 №6

болон аюулгүй байдлын орон зайд тунхаглан ашиглаж байна. Тэргүүлэх хөгжилтэй хичирхэг улс гүрнүүд дэлхий дахин, бус нутгийн орон зайд өөрсдийн нөлөөллөө хадгалах, улс орныхоо тогтвортой байдал, хил хязгаар, аюулгүй байдлаа хангах зорилгоор улс төр, эдийн засаг цэрэг батлан хамгаалахын бодлого ёл ажиллагаагаа идэвхтэй явуулсаар байна. Хүн төрөлхтний хөгжлийн явцад улс орнууд хөгжилтэй, дунд хөгжилтэй /хөгжингүй/, хөгжиж байгаа буурай хөгжилтэй зэргээр тэнцвэртэй бус хөгжлүүр ялгаран хичирхэг улс төр, эдийн засаг, цэрэг зэвсэг бхий улс орнууд дэлхий дахин болон бус нутгийн хөгжил цэцэглэлт, аюулгүй байдлын орчинд хчтэй оролцоо нөлөөгөө злсээр ирэв.^{1 11}

Хилийн төлөөлөгчийн албаны ёл ажиллагааг Монгол Орос, Монгол Хятадын хилд дараах удирдлага зохион байгуулалттайгаар явуулж байна.

Монгол, Оросын хилд ажиллах хилийн бэрэн эрхт төлөөлөгчийн бэрэлдэхүүнд:

- Хилийн бэрэн эрх төлөөлөгч:
- Хилийн бэрэн эрхт төлөөлөгчийн орлогч:
- Хилийн бэрэн эрхт төлөөлөгчийн туслагч:
- Нарийн бичгийн дарга:
- Орчуулагч:
- Мэргэжилтэн:
- ёйлчилгээний ажилтан:

Монгол, Хятадын хилд ажиллах хилийн төлөөлөгчийн бэрэлдэхүүн:

- Хилийн төлөөлөгч:
- Хилийн төлөөлөгчийн орлогч:
- Хилийн төлөөлөгчийн туслах:
- Уулзалтын цэгийн дарга:
- Нарийн бичгийн дарга:
- Орчуулагч:
- Мэргэжилтэн:
- ёйлчилгээний ажилтан багтана.

¹ А.Энхтөр Хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал УБ, 2021 он, 11 дэх тал.

Хил хамгаалах байгууллага нь хилийн асуудлаар байгуулсан Монгол Улс, Орос улсын хооронд 15, Монгол улс бусад улсын хооронд 24 нийтдээ 39-н гэрээ, хэлэлцээрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Хил хамгаалах ерөнхий газарт хилийн төлөөлөгчийн албаны үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгж нь Хилийн цэргийн штаб, Хилийн алба, хилийн төлөөлөгчийн газар, Хилийн төлөөлөгчийн хэлтэс юм.

Хил хамгаалах байгууллагын удирдлагын хил залгаа болон бусад гадаа улс орнуудын ижил төстэй байгууллагатай гадаад харилцааны үйл ажиллагааны асуудлыг хариуцах нэгж нь:

-Хил хамгаалах ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар,

-Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс хариуцан, төлөвлөлт, зохион байгуулалт, төлөвлөлтийн хэрэгжилтийн явц, мөрдөнд хяналт тавин ажиллаж байна.

Хилийн отряд /анги/-ын хилийн төлөөлөгчийн албыг Ангийн штаб, Хилийн албаны тасаг, Шалган нэвтрүүлэх албаны асуудалтай холбоотой хилийн төлөөлөгчийн ажиллагааг шалган нэвтрүүлэх алба хариуцан ажиллаж байна.

Зураг 1. Хилийн төлөөлөгчийн албаны удирдлага



Хилийн төлөөлөгчийн албаны ёйл ажиллагааны харилцаанд Хилийн цэргийн штаб асуудлыг дээд хэмжээнд шийдвэрлэхэд ОХУ-ын хилийн алба, бөсийн хилийн удирдах газарт, БНХАУ-ын цэргийн тойрогт болон ХАЧА-ийн удирдлагад ханддаг. Асуудал бэрэн шийдэгдэж чадаагүй ёед ХЗДХЯ-аар дамжуулан ГХЯ-аар дипломат шугамаар шийдвэрлөхээр ханддаг бол ОХУ-ын талд хилийн бэрэн эрхт төлөөлөгчийн хэмжээнд шийдэж чадаагүй асуудлаа бөсийн хилийн удирдах газарт, бөсийн хилийн удирдах газраар шийдэж чадаагүй тохиолдолд ХАБА-ны Хилийн албанд, бэрэн шийдвэрлэж чадаагүй асуудлыг ХАБА-аар дамжуулан ГХЯ-нд шилжүүлдэг, БНХАУ-ын хувьд хилийн төлөөлөгчийн шугамаар шийдэж чадаагүй ёед Цэргийн тойрогт шилжүүлдэг бөгөөд уг асуудал бэрэн шийдэгдэж чадаагүй тохиолдолд ХАЧА-ийн Хил хамгаалалтын албаар дамжуулан ГХЯ-ндаа мэдэгдэж шийдвэрлүүлдэг.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 36 дугаар зөйлд Улсын хил хамгаалах байгууллагын бэрэн эрхэд “Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг шалгах зорилгоор зургаан цагаас илүүгүй хугацаагаар тэр саатуулах, зөрчил гаргасан этгээдийн баримт бичгийг шалгах, түүний өмчлүүлд эсхүл эзэмшилд байгаа эд зөйл, бие өзлэг хийх, эд зөйл баримт бичгийг тэр хугацаагаар хураан авах, битүүмжлэх, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлүүлэх бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдүүдийг мөрдөх ёед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох, тэр саатуулагдсан этгээдийг эд зөйл, биед өзлэг хийсэн, эд зөйл, баримт бичгийг хураан авсан тохиолдол бөрт хуульд заасны дагуу тэмдэглэл өйлдэх эрхтэй болсон. Энэ бэрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, зөрчлийн тухай хуулиудын холбогдох заалтуудыг баримтлан ажиллах шаардлага урган гарч байна.

Хилийн /бэрэн эрхт/ төлөөлөгч, орлогч, туслах нь зөрчил шалган шийдвэрлэхдээ дараах бэрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

- Хуулиар харьяалуулсан зөрчлийг илрүүлсэн эсвэл зөрчлийн тухай гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх:
- Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, бүртгэх:
- Хуульд заасан нөдөслэл, журмын дагуу зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах, эсхүл зөрчлийн хэрэг нээх:
- Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх саналыг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтанд гаргах:
- Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан нөдөслэл, журмын дагуу явуулах:
- Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийх:
- Прокурорын шийдвэр, үйл ажиллагааны талаар хуульд заасан журмын дагуу тухай нэгжийн дээд шатны прокурорт гомдол гаргах:
- Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн гаргасан хүсэлтийг хуульд заасан нөдөслэл, журмын дагуу шийдвэрлэх:
- Хуульд заасан нөдөслэл, журмын дагуу эрх хязгаарлах арга хэмжээг хэрэглэх:
- Хуулиар харьяалуулсан зөрчилд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авах:
- Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авч, зардлыг нөхөн төлүүлэх:

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулсан шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгахтай холбоотой зардлыг нөхөн төлүүлгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах зэрэг эрхийг хэрэгжүүлж байна.¹

Хоёр.Хилийн төлөөлөгчийн албаны удирдлага, зохион байгуулалтад тулгамдаж буй зарим асуудлыг сайжруулах нь. Манай Улсын хил хамгаалалтын нөхцөлийн цагийн байдлыг дүгнэн үзвэл уламжлалт хилийн зөрчлөөс гадна хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг галт хэрэгсэл, хүний наймаа, хориглосон бараа бүтээгдэхүүн, төмхийн нэт эд зүйлс, ховор ан амьтан, ургамал

¹ ЭХХШТХ-ийн 23, 25, 27 дугаар зүйл. Төрийн мэдээлэл. 2017 . №23

зэргийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчил таслан зогсоогдохгүй цаашид өрсөн нэмэгдэх хандлагатай байна.

Хилийн цагийн байдлаас шалтгаан хилчдийн арга тактик, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөлтэй уялдуулан хилийн төлөөлөгчийн албаны өйл ажиллагааг боловсронгуй болгох, хөрш орнуудын хилийн төлөөлөгчийн хамтын ажиллагааг идэвхитэй явуулах шаардлага байсаар байна.

Хилийн төлөөлөгчийн албаны удирдлага зохион байгуулалт, төлөхөн хөгжил, өнөөгийн байдалд хийсэн дүгнэлтэд тулгуурлан энэхүү илтгэлийн хөрөөнд дараах тулгамдсан асуудал байна гэж үзэж байна.

Нэг. Манай улсын хилийн төлөөлөгчийн албаны удирдлагын зохион байгуулалт, ажлын албыг нэгт хилийн цэргийн штаб, хоёрт захиргааны удирдлагын газарт харьяалуулсан нь зарим талаараа нэгтгэн удирдахад цаг хугацаа алдах, өөр өөр нөхцөл байдалд удирдлагын шийдвэр гаргахад сөрөөр нөлөөлж болзошгүй тул хилийн цэргийн штабт бэрэн харьяалуулах.

Хоёр. Хилийн төлөөлөгчийн албаны орчуулагч нь хилийн уулзалт, хамтарсан шалгалтын өөд аман болон бичгийн орчуулгыг хоёрдмол утгагүй хийх, мэргэжлийн болон дипломат албаны хэллэг ашиглах, сэтгэл хөдлөлийг илэрхийлэхгүй, биеийн хэлэмж зөв ашиглах өөрөгтэй байдаг. Хилийн төлөөлөгч /бэрэн эрхт/-ийн, орлогчийн, туслахийн хэмжээний уулзалт, хамтарсан шалгалт, хоёр талын хамтын ажиллагаанд орчуулга мэргэжлийн төвшинд хийгдэж байж, цаашид өр дөнтэй өргөлжилэн асуудалд эрх тэгш хандана. харин зарим хилийн отряд /анги/-ын орчуулагч нар мэргэжлийн бус, ажлын туршлага дутмаг, мэргэжлийн өг хэллэг сайнгүй байдаг нь уулзалтын санаачлагыг алдах, улмаар асуудлыг оновчтой шийдвэрлэхэд сөрөөр нөлөөлж болзошгүй байдаг. Харьцуулвал: Хятадын хилийн төлөөлөгчийн бэрэлдэхүүнд орчуулагч нар нь ихэвчлэн ӨМӨЗО-ны алба хаагч нар байдаг тул орчуулгын явцад ямар нэгэн хөндрөл өөсдөггүй, уулзалтын санаачлагыг авах оролдлоготой байдаг нь анзаарагддаг. Иймд хилийн төлөөлөгчийн албаны орчуулагч нар нь ажлын туршлагатай, мэргэжлийн өг хэллэг, биеийн хэлэмжийг сайтар эзэмшсэн, мэргэжлийн орчуулагч нар байх шаардлагатай байна.

Гурав. Хилийн төлөөлөгчийн албаны бүрэлдэхүүн дипломат арга хэмжээний талаарх мэдлэг хангалтгүй байдаг нь албаны үйл ажиллагаанд сөрөг нөлөөлдөг тул зайлшгүй эзэмших шаардлага болгон Хилийн төлөөлөгчийн албаны бүрэлдэхүүнд дипломат арга хэмжээний талаарх сургалтыг тусгай хтөлбөр р явуулах

Дөрөв. Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг 2017 оноос хилийн төлөөлөгч, орлогч, туслах нь зөрчил шалган шийдвэрлэх, хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрхтэй болсон. Хилийн төлөөлөгч, төмний бүрэлдэхүүн нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хлээн авснаас хойш 5 хоногийн дотор хойшлуулшгүй ажиллагааг эрхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ндэслэл, журмын дагуу явуулах эрхтэй. нд:

Злэг хийх, шинжилгээнд зориулж дээж, хурааны хээ, ул мөрийн хэв авах, гэрчээс мэдлэг авах, хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хураах, эд хөрөнгийг битлмжлэх, харьяаллын дагуу саналаа прокурорт даруй шилжүүлэх гэх мэт зөрчил шалган шийдвэрлэх, хойшлуулшгүй ажиллагаа, эрхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мэргэжлийн албаны онцлогийн мэдлэг чадвар сул байгаагаас манай зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд ажлын хариуцлага алдаж, эргээд өөрсдөө хариуцлага хлээдэг, хлээх магадлал ндөр байна.

Мэргэжлийн албаны онцлог шаардсан эрх, өөргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэх мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад тогтмол явуулах нь зүйтэй гэж злээ.

Дүгнэлт. Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа нь Төрийн с хилийн талаар баримтлах бодлого, хилийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжууд, Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон Улсын гэрээ хэлэлцээр, хоёр талын хамтын ажиллагааны проткол, санамж бичиг бусад эрх зүйн баримт бичгүүдийн удирдлага гэрээгээр хлээсэн бүрэн эрх, өөргээ хэрэгжүүлэх, улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт улс орны, иргэдийн арх ашгийг хамгаалахад үйл ажиллагаагаа бусад

алба нэгжтэй уялдуулан зохицуулах замаар биеллэх зорилтод чиглэгддэг.

Дээрх зорилтод нийцүүлэн хилийн төлөөлөгчийн уулзалт бүрт зорилт дэвшүүлэн төлөвлөлтөд дээд штабаас өгсөн чиглэлд тулгуурлан, хэлэлцэх асуудал, баримтлах зарчим, нөхцөл талаас тавьж болзошгүй асуудлууд, өгөх хариултуудыг бодитой тооцон гаргах нь үр дүнд хүрдэг болно.

Аливаа хилийн асуудлыг олон нэгжтэй хууль эрх зүйн үндэслэлтэй авч үзэх, байр сууриа чадварлаг илэрхийлэх, харилцагч талдаа ойлгомжтой болгох нь хилийн төлөөлөгчийн албаны удирдлага зохион байгуулалтын гол арга болдог байна.

Хилийн асуудал зөрчил будиланыг шударгаар шийдвэрлэх нь улсын хил дээр тогтвортой байдал, сайн хөршийн харилцааг хангах нэг үндэс юм.

Хилийн төлөөлөгчийн албаны үйл ажиллагааг удирдахуй ухааны шинэ чиглэл рэгтэй харьцуулан, удирдлагын дээрээс доош төвшин рүү төлөвлөлтийг тодорхой хугацаагаар боловсруулан баталгаажуулж, зохион байгуулалтын хувьд онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх, бусад бүрэн эрхийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэх, албанд манлайллыг бий болгож, өмнө тавьсан зорилтыг биелүүлэхэд идэвхжүүлэх, хяналт шалгалтыг тухай бүрт явуулснаар гарч болох алдаа доголдлыг илрүүлэх, таслан зогсоох, зарим тохиолдолд төлөвлөлтөд нэмэлт зөрчлөлт оруулах замаар удирдлагын тасралтгүй байх зарчмыг хэрэгжүүлэх нь энэ албаны гүйцэтгэж буй үүрэг, хүлээх хариуцлага илүү сайжрах, алдаа доголдол гаргахгүй байх, улсын хилийн аюулгүй байдал хангагдах нөхцөлдийн үндэс болно.

Хилийн төлөөлөгчийн алба нь олон улсын гэрээгээр эрх зүйн хувьд баталгаажуулж өгсөн арга хэлбэрээр явагддаг бөгөөд дипломат арга хэмжээ, удирдахуй ухааныг зайлшгүй судлан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна гэж үзээд дараах саналыг дэвшүүлж байна.

Санал

Нэг. Хилийн төлөөлөгчийн албаны удирдлага зохион байгуулалт, ажлын албыг нэгт хилийн цэргийн штаб, хоёрт захиргааны удирдлагын газарт харьяалуулсан нь зарим талаараа

нэгтгэн удирдахад цаг хугацаа алдах, нэр нэр нэхцэл байдалд удирдлагын шийдвэр гаргахад сөрөг нөлөлж болзошгүй тул хилийн цэргийн штабт бэрэн харьяалуулах.

Хоёр. Хилийн төлөөлөгчийн албаны орчуулагч нарыг мэргэшлэх, дипломат албаны мэргэжлийн төвшинд ажиллуулах

Гурав. Хилийн төлөөлөгчийн албаны бэрэлдэхнийг хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон Улсын гэрээ, хэлэлцээр, дипломат арга хэмжээний талаарх мэдлэг чадварыг сайжруулах

Дөрөв. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад зөрчил шалган шийдвэрлэх, хойшлуулшгүй ажиллагаа явуулах, эрхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бэрэн эрхээ хэрэгжлэх ур чадварыг төгс олгох зэрэг тулгамдсан асуудлуудыг шаттайгаар шийдвэрлэвэл хилийн төлөөлөгчийн албаны үйл ажиллагаа нь боловсронгуй болгоход нэтэй хувь нэмэр оруулах болно гэсэн дүгнэлтийг хийж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын Хилийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017 №6

Дагважамц.Г Хилийн дипломат ажиллагаа. УБ., 2010 он

Ганболд.Ц “Монгол Улсын хилийн төлөөлөгч, төний үйл ажиллагааг боловсронгуй болгох нь” УБ., 2004 он

Ганболд.Ц Хилийн төлөөлөгчийн ажиллагаа. УБ., 2006 он

Бидний менежмент Ц.Цэрэндорж, С.Цэрэнжав. УБ., 2013 он

Энхтөр.А Хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал. УБ., 2021 он